

БАТЛАВ
“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Ихэвчлийн* Ц.ЭНХТУВШИН

2024 оны 05-р сарын 28-ний өдөр

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Байршил:

Налайх дүүрэг, 2-р хороо, КВТС-20/150 зуухны барилгын ойр орчимд буюу станцын эзэмшлийн газар дээр.

Ажлын цар хүрээ:

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн КВТС-20/150 зуухны гадна талбайд гүний усны 2 ширхэг худаг ухаж, насос суурилуулан ашиглалтад оруулах.

Тавигдах шаардлагууд:

№	Үзүүлэлт ба тавигдах шаардлага
1. Цооногийг өрөмдөх, цооногийг тоноглох	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох
1.2	Цооногийн “Шавхалт туршилт”-ын ажлыг хийж гүйцэтгэж дүгнэлт гаргах.
1.3	Цооногийн ашиглалтын ундарга: 12-15тн/ц ба түүнээс дээш
1.4	Цооногт суурилуулах насосын напор 120 метр ба түүнээс дээш
1.5	Ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй байх
1.6	Худгийг түр хугацааны тагаар тоноглох
1.7	Худгийн насосын ус шахах хоолойг КВТС-20/150 зуухны үns зайлзуулах шугамруу болон үnsэн санруу хаях шугамаар тоноглох
2.Худгийн насос, цахилгааны утас хянах самбар	
2.1	Гүний насос: ISO-9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглахад тохиромжтой байх.
2.2	Цахилгаан утас: <ul style="list-style-type: none">Суурилагдсан хөдөлгүүрийн ачааллыг бүрэн даах чадвартай байх.Насосын хянах самбар хүртэл үргэлжилсэн, залгаагүй, ус өргөх янданд 3 метр тутамд бэхэлгээ хийж тогтоох.
2.3	Хянах самбар: <ul style="list-style-type: none">КВТС-20/150 зуухны хяналтын өрөөнд суурилуулах.Асаах, унтраах товчлууртай байх.Насосын ачааллыг хянах боломжтой байх.
3.Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх.	
3.1	Худгийн паспортыг бэлтгэх.
3.2	Талбайг цэвэрлэх.

Нийлүүлэгч байгууллага:

- Чанарын шаардлага хангасан /Хүснэгт 1/-т заасан барааг гэрээний хугацаанд нийлүүлж гүйцэтгэх.
- Зах зээлийн тогтвортой үнийн өсөлтөөс үүссэн зэрэг бусад шалтгаанаас үл хамааран шаардлагатай хугацаанд гэрээ байгуулан гүйцэтгэж өгөх.
- Шаардлагатай зөөвөрлөх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байна.

Захиалагчийн хяналт:

- Хийгдэж буй ажил нь техникийн тодорхойлолт, мөрдөгдөж буй стандартад нийцсэн, захиалагчийн хүсэлтийг хангасан байх.
- Ажлыг шалгах явцад илэрсэн доголдлыг арилгуулах.
- Гүйцэтгэсэн ажилтай холбогдуулан гарах тайлан, холбогдох материалуудыг захиалагч талд жагсаалтын дагуу хүлээлгэж өгөх.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

М.ЛХАГВАСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ЦХА-ЫН ИНЖЕНЕР

Б.ТЭНГИС

